



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗАР

Ж.Самбуугийн гудамж 18, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот 15170, Утас: 26 15 44,
Цахим шуудан: info@supremecourt.mn

2024. 08. 28 № 05/4404
танай _____-ны № _____-т

Тендер шалгаруулалтыг
үргэлжлүүлэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газраас зарласан УДШ/20240101002 дугаартай “Улсын дээд шүүхийн их засвар” /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг сонирхогч этгээдээс Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт гомдол гаргасантай холбогдуулан тендер шалгаруулалтыг түр түдгэлзүүлсэн.

Тус газрын 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 01/1494 дугаартай албан бичгээр захиалагч тендерийн баримт бичгийн ТШЗ-ын 18.1-д заасан шалгуур үзүүлэлтийг Сангийн сайдын 2024 оны А/259 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийн дагуу боловсруулсан байх тул өрсөлдөөнийг хязгаарласан гэж үзэх үндэслэлгүй байна гэж хянажээ.

Иймд тендер шалгаруулалтыг баримт бичгийн тендер хүлээн авах эцсийн хугацаа болон тендер нээх хугацааг дараах байдлаар өөрчилж байгааг үүгээр мэдэгдэж байна. Үүнд:

1. Тендер хүлээн авах хугацаа нь: 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 11 цаг 40 минут;
2. Тендер нээх хугацаа: 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 11 цаг 50 минут;

ДАРГА



С.ЗАЯАДЭЛГЭР



УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024.08.28 № 01/1494

танай _____-ны № _____-т

**Тендерийн баримт бичгийг
хянасан тухай**

Танай шүүхээс зарласан “Улсын дээд шүүхийн их засвар” /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ УДШ/20240101002 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Роуд дэвэллопмент” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянан үзлээ.

Тендерийн баримт бичгийн ТШЗ 18.1-д “Санхүүгийн чадавхын шаардлага: Шаардана, 2. Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна” гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална” гэж, мөн Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/259 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д “Санхүүгийн чадавхын шаардлага: [“Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэж бичнэ, Хэрэв шаардах бол дор дурдсан шаардлагаас гэрээний үүргийн гүйцэтгэлд ач холбогдол бүхий доод шалгуур үзүүлэлт, шаардлагыг тусгах ба үүгээр хязгаарлагдахгүй, ...Түргэн хөрвөх хөрөнгөтэй холбогдох шаардлага...” гэж тус тус заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичгийн ТШЗ 18.1-д заасан шалгуур үзүүлэлтийг Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/259 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн дагуу боловсруулсан байх тул өрсөлдөөнийг хязгаарласан гэж үзэх үндэслэлгүй байна.

Иймд тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулна уу.

ДАРГА



Б.БИЛГҮҮН

0002210